БАТЛАВ.
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Ч.МӨНХТУЯА

2024 оны ..4.. дугаар сарын ..03.. -ний өдөр

# НИСЛЭГИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБАНЫ АЖИЛТНУУДЫН ДҮРЭМТ ХУВЦАСНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## 1. Дүрэмт хувцасны зориулалт, төрөл болон тоо хэмжээ

Иргэний нисэхийн тухай хуулийн 8.3 “Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагч тусгай дүрэмт хувцас хэрэглэнэ”, Зам тээврийн сайдын 2015 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 123 дугаар тушаал “Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагчийн тусгай дүрэмт, хувцасны загвар”, ИНЕГ-ын даргын 2015 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/343 тушаалтын хавсралтаар баталсан “Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагчийн тусгай дүрэмт хувцас хэрэглэх журам”-д тус тус заасны дагуу Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт шалгалтын үйл ажиллагаа хийх үед хяналтын байцаагч нь дүрэмт хувцастай байна.

2024 оны батлагдсан төсвийн хүрээнд дараах төрөл, тоо хэмжээгээр байцаагчийн дүрэмт хувцасыг захиалан оёулах /эрэгтэй, эмэгтэй костюм, зангиа/, худалдан авна /Нимгэн цагаан цамц, Ноосон цамц худалдан авах, логог оёулах/.

*Дүрэмт хувцасны төрөл, тоо хэмжээ*

| д/д | Бараа материалын нэр | | Хэмжих нэгж | Тоо, ширхэг |
|---|---|---|---|---|
| 1 | Дүрэмт хувцас | Эрэгтэй костюм | ширхэг | 26 |
| 2 | | Эмэгтэй костюм | ширхэг | 17 |
| 3 | | Зангиа | ширхэг | 43 |
| 4 | | Нимгэн цагаан цамц (эрэгтэй-урт ханцуйтай сорочкин) | ширхэг | 26 |
| 5 | | Нимгэн цагаан цамц (эмэгтэй-урт ханцуйтай сорочкин) | ширхэг | 17 |
| 6 | | Ноосон хөх цамц (эрэгтэй) | ширхэг | 26 |
| 7 | | Ноосон хөх цамц (эмэгтэй) | ширхэг | 17 |

## 2. Ерөнхий шаардлага:

Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагчийн дүрэмт хувцас нийлүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна:

1. Тендерийн баримт бичигт заасан тооны чанар нь захиалагчид ирүүлсэн загварын хувцаснаас материал, чанар, өнгө, хийцийн хувьд ялгаагүй ижил, зөрүүгүй, адил байна. Ялгаа, зөрүү гарсан тохиолдолд захиалагч ирүүлсэн хувцсыг гүйцэтгэгчид буцааж, тендерийн баримт бичигт заасан, шаардлага хангасан хувцасаар солиулна.

2. Захиалагчид нийлүүлэх хувцас нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй заасан өнгөнөөс зөрүүгүй байна.

3. Бүх хувцас хэрэгсэлд орсон материал нь олон улсын холбогдох стандартын шаардлага хангасан, хүний биед харшил үүсгэх, арьс салстыг цочроох үйлдэлгүй, өнгөн хэсэгт баагнарал /шарик/ үүсэхгүй байх.

4. Хувцас хэрэгслийг хийсэн, орсон материал нь хүний биед сөрөг нөлөөгүй, биеийн хөлстэй урвалд ордоггүй материалаар хийгдсэн байна.

5. Дүрэмт хувцас нь загвар материал, хийц сайтай, будаг гардаггүй байх.

6. Хувцас нь хүний хөдөлгөөнд саад болохгүй байх ба ашиглахад эвтэй (өмсөж, тайлахад хялбар, халаас товчны оновчтой байрлал) байна.

7. ИНЕГ-ын даргын 2015 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/343 тушаалтын хавсралтаар баталсан “Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагчийн тусгай дүрэмт хувцас хэрэглэх журам”-д заасны дагуу 2 жил хэрэглэх, эдэлгээ даах боломжтой байх.

8. Угаалга, арчилгааны шошго, хувцасны хэмжээ, арчилгааны заавар болон бусад шаардлагатай мэдээллийг хувцас тус бүрт оёж тогтоосон байна.

9. Дүрэмт хувцасны зүүн энгэр

## 3. <u>Тусгай шаардлага:</u>

**a.** Дүрэмт хувцас нь “MNS 6231:2011” стандартын шаардлагыг хангасан байх шаардлагатай бөгөөд өнгө, загвар бараа, материал тус бүрд дараах шаардлагыг хангасан байна.

<table>
<tr><th>Д/д</th><th>Бараа материалын нэрс</th><th>Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага</th><th>Жишиг зураг</th></tr>
<tr><td>1</td><td>Эрэгтэй костюм /хүрэм өмд/</td><td rowspan="2"><u>Загвар:</u> Ганц эгнээ 2 товчтой, биед эвтэйхэн хагас бариу хүрэм хажуугийн хоёр халаастай, цээжний нэг халаастай. Ар талын хажуугийн оёдолд салхи нэвтрүүлэх зүсэлттэй. /эмэгтэй хүрэм зүсэлтгүй/. Хүрэмний зүүн энгэрийн өргөнийг голлуулж “Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч”-ийн Логог харагдац тод байхаар хатгаж оёсон байна.<br>/зүүн ханцуйнд хяналтын байцаагчийн лого /7,5*8,5см/, баруун дээд энгэрт байгууллагын лого оёсон байна<br><br><u>Өнгө: Хар хөх өнгөтэй.</u><br><u>Гадна материал</u>: 100%, Ноосны хольц бүхий даавуу (44% ноос, 54% полиэстер, 2% эластан), тос, ус нэвтрүүлэхгүй боловсруулалттай, индүүдлэг даах чадвар сайн, бат бөх, элэгдэлд тэсвэртэй, агаар нэвтрүүлдэг. Гадаргуугийн цахилгаанжилтын эсэргүүцэл 10 ОМ-оос ихгүй, будаг гарахгүй байна.</td><td></td></tr>
<tr><td>2</td><td>Эмэгтэй костюм /хүрэм, өмд эсвэл юбка сонголтоор/</td><td><br><br></td></tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Дотор материал: 100% полиэстер, механик суналттай бүтэцтэй, цахилгаанжилтгүй боловсруулалттай.<br>Байгууллагын лого: | |
| 3 | Зангиа | | Хар хөх, хөвөн даавуун материалтай, доод үзүүрт байгууллагын бэлгэдэл логог хатгаж оёсон байх | |
| 4 | Эрэгтэй срочикон цамц | Материал, өнгө<br>Зах<br>Энгэр<br>Ханцуй<br>Суга<br>Халаас<br>Лого, таних тэмдэг | Өдөр тутам өмсөх цагаан өнгөтэй. Материалын даавууны агууламж 35*65 хувь байх ба наалдамхай хольц (65% полиэстер- polyester / 35% нейлон- viscose), нягт 160 г/м2. Размер: 38-48, Өндөр: 170-185. Цамцны доод хэсэг резинтэй хэрж оёсон байна. Цээж энгэр хэсэгт 2 халаастай ба мөрний дээд хэсэгт мөрдөс тогтоогчтой байна. Урт ханцуйтай, зүүн ханцуйнд хяналтын байцаагчийн лого /7,5*8,5см/, баруун дээд энгэрт байгууллагын лого оёсон байна |  |
| 5 | Эмэгтэй срочикон цамц | Материал, өнгө<br>Зах<br>Энгэр<br>Ханцуй<br>Суга<br>Халаас<br>Лого, таних тэмдэг | Өдөр тутам өмсөх цагаан өнгөтэй стандарт цамц, Материалын даавууны агууламж наалдамхай хольц (51% хөвөн, 45% полиэстер, 4% эластан), нягт 132 г/м2.<br>Товчтой зүүн энгэрийн дээр болон зүүн мөрнөөс доош хэсэгт байгууллагын бэлгэдэл логотой байна.<br><br>Урт ханцуйтай, зүүн ханцуйнд хяналтын байцаагчийн лого /7,5*8,5см/, баруун дээд энгэрт байгууллагын лого оёсон байна<br><br>Размер: 76-128, Өндөр: 158-176. |  |
| 6 | Ноосон цамц | Материал, өнгө<br>Зах<br>Энгэр<br>Ханцуй<br>Суга<br>Халаас | Өдөр тутам өмсөх хар хөх өнгөтэй. Тохойн хэсэгт үрэлт, хэв гажилт үүсэхээс сэргийлсэн байх;<br>Материал даавууны найрлага: 30% ноос / 70% PAN.<br>Размер: 92-128, Өндөр: 158/164-182/188.<br>Зүүн энгэрийн халаастай байна. Хүзүүний хэсэг О хэлбэртэй. Цамцны доод хэсэг резинтэй. |  |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Лого, таних тэмдэг | мөрний дээд хэсэгт мөрдөс тогтоогчтой байна. Зүүн энгэрийн халаасны дээр болон зүүн мөрнөөс доош хэсэгт байгууллагын бэлгэдэл логотой байна. | |

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БЭЛТГЭСЭН:

Иргэний нисэхийн ерөнхий газрын
Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт,
зохицуулалтын албаны Зөрчил хянан шийдвэрлэх
ажил хариуцсан хяналтын байцаагч П.Батбаяр

Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн газрын
хангамжийн мэргэжилтэн А.Чойжамц

“ХУД Яармаг”
Төрийн бус байгууллагын гишүүн
Үнэлгээний хорооны гишүүн: Б.Наранцацрал

“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төвийн төв”
Төрийн бус байгууллагын тэргүүн
Үнэлгээний хорооны гишүүн: Б.Мэндсайхан

Хөрөнгө оруулалт, захиалагчийн албаны
Худалдан авах ажиллагааны тасгийн
мэргэжилтэн А.Баянжаргал